

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОО-2025/003/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 70584207, Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn Аудитор: Ч.Удвалноров Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-9
3. Аудитын илрүүлэлт	10-11
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	11-12

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БЧШ	Боловсролын чанарын шинэчлэл
ДОА	Дорнод аймаг
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.25 № 332

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Л.ХИШИГТОГТОХ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын 2023 оны 306 дугаар тогтоолын дагуу Дорнод аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг тус сургуультай нэгтгэх тухай шийдвэр гарсантай холбоотойгоор тайлант хугацаанд санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

011022146

Бусад асуудал

Дорнод аймаг дахь Политехник коллеж нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 53 арга хэмжээ, үүнээс тусгайлан хэрэгжүүлэх 7 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж тайлагнасан, гүйцэтгэлийн тайлангийн биелэлтийн дүгнэлт Боловсролын ерөнхий газраас хараахан үнэлэгдэж ирээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	1,863,572,869.23
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	660,577,253.44
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	660,577,253.44
3121	Төгрөг	-	660,577,253.44
31211	Төрийн сангийн харилцах	-	645,132,485.59
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	15,444,767.85
33	АВЛАГА	-	25,335,807.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	46,807.00
335	Бусад авлага	-	25,289,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	25,289,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	1,177,659,808.79
351	Түүхий эд материал	-	686,351,721.69
35110	Тусгай зориулалттай материал	-	686,351,721.69
354	Хангамжийн материал	-	435,618,087.10
35410	Бичиг хэргийн материал	-	1,265,000.00
35420	Аж ахуйн материал	-	361,711,826.10
35430	Сэлбэг хэрэгсэл	-	1,727,000.00
35450	Барилгын засварын материал	-	7,142,700.00
35470	Бусад хангамжийн материал	-	63,771,561.00
35600	Мал амьтад	-	55,690,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	10,817,061,940.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	10,817,061,940.70
392	Биет хөрөнгө	-	8,881,801,108.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	9,641,915,061.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,632,602,351.58)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	619,633,543.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(388,574,102.41)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	4,268,885,733.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(3,641,626,886.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	295,741,967.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(224,183,351.14)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	949,818,176.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(94,981,817.64)
39217	Ном	-	87,775,136.80
393	Биет бус хөрөнгө	-	1,935,260,832.00
39301	Програм хангамж	-	38,251,535.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(37,981,535.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	1,934,990,832.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	12,680,634,809.93
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	12,680,634,809.93
51	Засгийн газрын хувь оролцоо	-	12,680,634,809.93
512	Хуримтлагдсан үр дүн	-	8,801,026,727.78
51210	Өмнөх үеийн үр дүн	-	(3,879,608,082.15)
51220	Тайлант үеийн үр дүн	-	12,680,634,809.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	3,879,608,082.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	12,680,634,809.93

Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	00.00	19,434,455,263.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	13,143,826,261.09
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	13,143,826,261.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	11,917,982,560.10
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	133,380,585.46
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	00.00	200,532,735.67
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	6,290,629,002.21
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	5,587,786,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	5,587,786,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	309,779,702.21
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	191,487,699.36
131107	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	00.00	118,292,002.85
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	393,062,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	393,062,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	00.00	6,753,820,453.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	6,753,820,453.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	6,286,241,882.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	3,608,933,519.00
210101	Үндсэн цалин	00.00	2,194,320,549.00
210102	Нэмэгдэл	00.00	1,035,751,740.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	155,642,199.00
210104	Урамшуулал	00.00	223,219,030.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	442,414,320.99
210201	Тэтгэврийн даатгал	00.00	307,619,401.20
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	35,203,315.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	18,441,805.84
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	15,810,928.77
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	65,338,869.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	287,512,010.22
210301	Гэрэл, цахилгаан	00.00	66,702,776.90
210302	Түлш, халаалт	00.00	155,244,152.32
210303	Цэвэр, бохир ус	00.00	65,565,081.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	45,121,863.84
210401	Бичиг хэрэг	00.00	5,686,100.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	14,619,035.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	4,914,845.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	16,705,722.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	3,196,160.64
2105	Нормативт зардал	00.00	143,619,832.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	1,314,670.00
210502	Хоол, хүнс	00.00	142,305,162.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	81,260,492.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	49,269,512.00
210604	Урсгал засвар	00.00	31,990,980.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	10,501,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	10,501,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,666,878,843.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	610,980,873.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	239,035,611.01
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	00.00	816,862,358.27

Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	467,578,571.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	362,027,881.47
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	173,217,831.47
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	180,752,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	8,058,050.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	105,550,689.78
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	105,550,689.78
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	00.00	12,680,634,809.93
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	00.00	12,680,634,809.93

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	6,599,253,323.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	333,913,321.13
120	Нийтлэг татварын бус орлого	-	333,913,321.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	333,913,321.13
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	133,380,585.46
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	-	200,532,735.67
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	6,265,340,002.21
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	5,587,786,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	5,587,786,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	284,490,702.21
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	166,198,699.36
131107	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	118,292,002.85
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	393,062,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	393,062,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	5,888,821,009.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	5,888,821,009.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	5,421,242,438.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	3,609,036,457.39
210101	Үндсэн цалин	-	2,194,320,549.00
210102	Нэмэгдэл	-	1,035,854,678.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	155,642,199.00
210104	Урамшуулал	-	223,219,030.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	442,358,189.60
210201	Тэтгэврийн даатгал	-	307,563,269.81
210202	Тэтгэмжийн даатгал	-	35,203,315.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	18,441,805.84
210204	Ажилгүйдлийн даатгал	-	15,810,928.77
210205	Эрүүл мэндийн даатгал	-	65,338,869.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	287,512,010.22
210301	Гэрэл, цахилгаан	-	66,702,776.90
210302	Түлш, халаалт	-	155,244,152.32
210303	Цэвэр, бохир ус	-	65,565,081.00
2105	Нормативт зардал	-	142,305,162.80
210502	Хоол, хүнс	-	142,305,162.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	81,260,502.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	49,269,522.00
210604	Урсгал засвар	-	31,990,980.00

Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	858,770,116.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	591,251,693.13
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	267,518,423.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	467,578,571.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	362,027,881.47
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	173,217,831.47
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	180,752,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	8,058,050.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	105,550,689.78
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	105,550,689.78
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	710,432,313.44
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	49,855,060.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	49,855,060.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	49,855,060.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	49,855,060.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(49,855,060.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	660,577,253.44
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	660,577,253.44

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(3,879,608,082.15)	-	(3,879,608,082.15)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(3,879,608,082.15)	-	(3,879,608,082.15)
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	3,879,608,082.15	-	-	3,879,608,082.15
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	12,680,634,809.93	-	12,680,634,809.93
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	3,879,608,082.15	8,801,026,727.78	-	12,680,634,809.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,697,385,200.00	5,276,567,435.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,697,385,200.00	5,276,567,435.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,326,961,400.00	4,914,539,554.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,732,902,000.00	3,609,036,457.39
210101	Үндсэн цалин	2,161,826,600.00	2,194,320,549.00
210102	Нэмэгдэл	1,409,287,800.00	1,035,854,678.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	161,787,600.00	155,642,199.00
210104	Урамшуулал	-	223,219,030.70

Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	466,612,700.00	442,358,189.60
210201	Тэтгэврийн даатгал	317,296,700.00	307,563,269.81
210202	Тэтгэмжийн даатгал	37,329,000.00	35,203,315.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,664,500.00	18,441,805.84
210204	Ажилгүйдлийн даатгал	18,664,500.00	15,810,928.77
210205	Эрүүл мэндийн даатгал	74,658,000.00	65,338,869.40
2105	Нормативт зардал	167,934,500.00	142,305,162.80
210502	Хоол, хүнс	167,934,500.00	142,305,162.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82,657,600.00	81,260,502.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	50,657,600.00	49,269,522.00
210604	Урсгал засвар	32,000,000.00	31,990,980.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	876,854,600.00	639,579,242.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	441,199,300.00	358,606,018.77
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	435,655,300.00	280,973,223.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	370,423,800.00	362,027,881.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	370,423,800.00	362,027,881.47
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	173,422,200.00	173,217,831.47
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	186,986,000.00	180,752,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,015,600.00	8,058,050.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,697,385,200.00	5,921,699,921.13
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,587,786,600.00	5,587,786,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,587,786,600.00	5,587,786,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	109,598,600.00	333,913,321.13
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	109,598,600.00	133,380,585.46
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	200,532,735.67
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	645,132,485.59
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	148	138
620001	Удирдах ажилтан	03	03
620002	Гүйцэтгэх ажилтан	103	93
620003	Үйлчлэх ажилтан	42	42
620004	Гэрээт ажилтан	00	00

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /орон нутаг/

Данс	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
	Мөнгө түүнтэй хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	393,062,700.00	287,512,010.22
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	393,062,700.00	287,512,010.22
210	Бараа үйлчилгээний зардал	393,062,700.00	287,512,010.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	393,062,700.00	287,512,010.22
210301	Гэрэл цахилгаан	85,405,400.00	66,702,776.90
210302	Түлш халаалт	210,857,300.00	155,244,152.32
210303	Цэвэр бохир ус	91,800,000.00	65,565,081.00
210304	Байрны түрээс	5,000,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	393,062,700.00	287,512,010.22
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	393,062,700.00	287,512,010.22
132001	Орон нутгийн төсвөөс	393,062,700.00	287,512,010.22
4	Мөнгө түүнтэй хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө түүнтэй хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	148	138
620001	Удирдах ажилтан	3	3
620002	Гүйцэтгэх ажилтан	103	93
620003	Үйлчлэх ажилтан	42	42

2.5.2 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	269,090,934.36
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	269,090,934.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	269,090,934.36
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	269,090,934.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	269,090,934.36
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	284,535,702.21
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	284,535,702.21
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,469,976.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	164,276,123.36
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	118,789,602.85
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,444,767.85

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 358,769.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

Залруулсан алдаа:

- Орон нутагт тогтвортой ажилласны тэтгэмж, өндөр насны тэтгэвэрт гарсны тэтгэмж зэрэг нэг удаагийн ажил гүйлгээнд 353.9 сая төгрөгийн давхар бичилт хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2. "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө" гэж заасантай нийцэхгүй байна.
- Үндсэн хөрөнгөд бүртгэгдэх 4.8 сая төгрөгийн үнийн дүн бүхий буйданг бараа материал дансанд бүртгэсэн байна.

Аудитаар нийт 11,174.0 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 906.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 10,268.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, 1 зөвлөмж хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

Томилолтоор ажиллах үед хоолны 906.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.

3.2 Албан шаардлага

Байгууллагын 2023 оны санхүүгийн жилийн тайланд өгсөн дүгнэлтийг үндэслэн санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогчийг 2 сарын, ахлах нягтлан бодогчийг 1.5 сарын, туслах нягтлан бодогчийг 1.5 сарын, 3 нярвыг тус бүр 1 сарын үндсэн цалингаар урамшуулсан байна. Тус сургуулийн нягтлан бодогч, нярав нарт санхүүгийн тайлангийн аудитаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсан гэх үндэслэлээр нийт 10,268.0 мянган төгрөгийн улирлын үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчин Засгийн газрын 2019

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

оны 5 дугаар тогтоолоор тогтоосон урамшууллын хэмжээг хэтрүүлэн олгосон, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн албаны ажилтнуудын ажлын байрны тодорхойлолттой холбоотой

Илрүүлэлт: Засгийн газрын 2023 оны 306 дугаар тогтоолын дагуу Дорнод аймаг дахь Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг тус аймаг дахь Политехник коллежид нэгтгэсэнтэй холбоотойгоор санхүүгийн албаны ажилтнууд болох Санхүүгийн албаны дарга-Ерөнхий нягтлан бодогч, Ахлах нягтлан бодогч-Эдийн засагч, Тооцооны нягтлан бодогч, нярав нарын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлээгүй байгаа нь ажил үүргийн хуваарийн давхардал үүсгэж байна.

Өгсөн зөвлөмж: Ажлын байрны зураглал хийж ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орон нутагт тогтвортой ажилласны тэтгэмж, өндөр насны тэтгэвэрт гарсны тэтгэмж зэрэг нэг удаагийн ажил гүйлгээнд давхар бичилт хийгээгүй байна.	1	353,969.8			1	353,969.8	1	353,969.8				
Үндсэн хөрөнгөд бүртгэгдэх үнийн дүн бүхий буйданг бараа материал дансанд бүртгэсэн байна.	1	4,800.0			1	4,800.0	1	4,800.0				
Нийт дүн	2	358,769.8	-	-	2	358,769.8	2	358,769.8				

Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Өмнөх оны санхүүгийн жилийн тайланд өгсөн дүгнэлтийг үндэслэн санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогчийг 2 сарын, ахлах нягтлан бодогчийг 1.5 сарын, туслах нягтлан бодогчийг 1.5 сарын, 3 нярвыг тус бүр 1 сарын үндсэн цалингаар урамшуулсан байна.	1	10,268.0			1	10,268.0							
Томиллолтоор ажиллах үед хоолны мөнгийг давхардуулан олгосон байна.	1	906.0	1	906.0									
Дорнод аймаг дахь Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг тус аймаг дахь Политехник коллежид нэгтгэсэнтэй холбоотойгоор санхүүгийн албаны ажилтнууд болох Санхүүгийн албаны дарга-Ерөнхий нягтлан бодогч, Ахлах нягтлан бодогч-Эдийн засагч, Тооцооны нягтлан бодогч, нярав нарын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлээгүй байгаа нь ажил үүргийн хуваарийн давхардал үүсгэж байна.	1	0					1	0					
Нийт дүн	3	11,174.0	1	906.0	1	10,268.0	1	0	-	-	-	-	



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 31/А1170629
20А-2025/003/НА-СТА-ТМС

Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан хаагчдад хоол, унааны хөнгөлөлтийг томилолтын зардалтай давхардуулан 906.0 мянган төгрөгийг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "..., ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулан тооцож олгосон 906,000.00 /Есөн зуун зургаан мянган/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан банкин дахь орон нутгийн хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймаг дахь Политехник коллежийн захирал Л.Хишигтогтох, ерөнхий нягтлан бодогч Д.Батбаяр нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА
АУДИТОР Ч.УДВАЛНОРОВ

2125050090



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 72 /А1170629

Чойбалсан хот

ДОА-2025/003/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймаг дахь Политехник коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагаа хариуцсан санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч, туслах нягтлан бодогч, нярав нарт 1-2 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 10,268.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2125040142

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Дорнод аймаг дахь Политехник коллежийн захирал Л.Хишигтогтох, ерөнхий нягтлан бодогч Д.Батбаяр нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  М.СЭМЖИДМАА
АУДИТОР  Ч.УДВАЛНОРОВ